

**БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН БАТЛАН
ХАМГААЛАХ ЯАМ, МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ЦЭРГИЙГ
УДИРДАХ ГАЗРЫН ХООРОНД ХИЛ ХАМГААЛАЛТЫН
АСУУДЛААР ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР**

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Батлан Хамгаалах Яам, Монгол Улсын Хилийн Цэргийг Удирдах Газар (цаашид хоёр Тал гэж нэрлэх)

1988 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн “Хятад, Монголын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулах тухай Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн Газар, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн Газар хоорондын гэрээ”, 1997 оны 11 дүгээр сарын 3-ний өдрийн “Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Батлан Хамгаалах Яам, Монгол Улсын Батлан Хамгаалах Яам хоорондын хамтын ажиллагаа, солилцооны тухай протокол”-ыг үндэслэн:

Хятад, Монголын хил орчмын тогтвортой, амар амгалан байдлыг хангах үүднээс итгэлцлийг бэхжүүлэх, хоёр улсын хилийн цэрэг, түүний харъяа ангиудын хооронд найрамдалт хамтын ажиллагааны харилцааг хөгжүүлэх зорилгоор:

Дор дурьдсан зүйлүүдийг хэлэлцэн тохиролцов.

Нэгдүгээр зүйл

Хоёр Тал Хятад, Монголын хилийг энх тайван, найрамдлын хил байлгахын төлөө чармайн хамтын ажиллагаа явуулна.

Хоёрдугаар зүйл

Хоёр Тал дараах байдлаар хамтран ажиллана. Үүнд:

1. Хил орчмын дэглэмийг сахиулахад чиглэгдсэн болон бусад холбогдох асуудлаар мэдээтэл солилцох;
2. Хил хамгаалалтыг удирдах, хилийн дэглэмийг сахиулах арга хэмжээний туршилага солилцох;
3. Хил орчмид гэмт хэрэг, будниан гарахаас урьдчилан сэргийлэх;
4. Улсын хилээр хууль бусаар зэвсэг, хордуулах болон мансууруулах бодис тээвэрлэх, контрабанд, хулгай дээрэм хийх зэрэг хууль зөрчсөн гэмт үйлдлийг таслан зогсоох;
5. Хилийн төлөөлөгчдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, хилийн асуудлыг үнэн зөвөөр шуурхай шийдвэрлэн, хил зөрчсөн хүн, малыг эрж хайн олох, хил

зөрчигсэд, тэдний уналга, хэрэгсэл, эд зүйлийг болон хил давсан мал, гэрийн гэжээвэр амьтдыг цаг тухайд нь нөгөө Талд хүлээлгэн өгөх;

6. Хил давж хохирол учруулж болзошгүй ойн болон тал хээрийн түймэр зэрэг байгалийн гамшиг, халдварт болон гоц халдварт өвчний талаар нөгөө Талдаа мэдээлж, хил давахаас сэргийлэх арга хэмжээг авах;

Гуравдугаар зүйл

Хоёр Тал дор дурьдсан хэлбэрээр харилцаа тогтооно. Үүнд:

1. БНХАУ-ын Батлан Хамгаалах Яам, Монгол Улсын Хилийн Цэргийг Уджрах Газрын удирдлага болон тэдний төлөөлөгчид шаардлагатай үед хоёр орны нийслэлд болон хоёр Талын хэлэлцэн тохирсон бусад газарт уулзаж, хилийн хамтын ажиллагааны асуудлаар яриа хэлэлцээ хийнэ.

Хоёр Тал харилцаагаа дипломат шугамаар дамжуулж явуулна.

2. БНХАУ-ын Ардын Чөлөөлөх армийн хилийн мужийн цэргийн тойргууд, Монгол Улсын Хилийн Цэргийн Штабын удирдлага болон тэдний төлөөлөгчид хоёр орны хилийн хотуудад болон Талуудын харилцан тохиролцсон газарт ээлжлэн жилд 1 удаа ажлын уулзалт хийж, өөрийн хамаарах хилийн бүсийн доторх хамтын ажиллагаа, хоёр Талын хилийн төлөөлөгчдийн дэвшүүлсэн чухал асуудлуудаар яриа, хэлэлцээ хийнэ.

Харилцааг хоёр Талын гадаад харилцааны байгууллага болон хилийн төлөөлөгчөөр дамжуулж явуулна.

3. Талуудын хилийн төлөөлөгчид хоёр Талын хилийн уулзалтын байр, хилийн хот, сууринд тодорхой хугацаанд ажлын уулзалт хийж, өөрийн хамаарах бүс нутгийн хил хамгаалах хамтын ажиллагааны асуудлаар яриа хэлэлцээ хийн, шаардлагатай тохиолдолд хилийн чухал асуудлыг газар тээр нь хамтран шалтгана.

Хоёр Тал харилцаагаа уулзалтын цэгүүдээр дамжуулж явуулна.

Дээр дурьдсан шат бүрийн албан тушаалтны яриа, уулзалтын үр дүнг товч тэмдэглэн, протокол буюу бусад төрлийн баримт бичгийн хэлбэрээр баталгаажуулан мөрдөнө.

4 дүгээр зүйл

Талууд дараах асуудлаар мэдээлэл үнэ төлбөргүйгээр солилцоно.

1. Хил орчмын амгалан тайван байдал, хилийн дэглэмд сөргөөр нөлөөлөх зүйлс;

2. Хүн, тээврийн хэрэгсэл, нисдэг хэрэгсэл хил давсан, хил давахаар завдаж буй талаар;

3. Хил зөрчигч бусад гэмт этгээд нөгөө Тал руу нууцаар оргон зайлсан, оргохыг завдаж буй талаар;

4. Нөгөө Талд хохирол учруулж болох байгалийн гамшиг, халдварт болон гоц халдварт өвчний талаар;

5. Улсын хилтээр хууль бусаар зэвсэг, хордуулах болон мансууруулах бодис, контрбанд, хулгай, дээрмийн зүйлс тгэвэрлэн нэвтрүүлсэн, нэвтрүүлэхийг завдсан талаар;

Солбицсон мэдээллийг мэдээлэл өгсөн Талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гуравдагч Талд задлаж буюу дамжуулж үл болно.

5 дугаар зүйл

1988 оны 11 сарын 28-ны өдөр гарын үсэг зурсан "БНХАУ-ын Засгийн газар, БНМАУ-ын Засгийн газар хоорондын Хятад, Монголын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулах тухай гэрээ"-ний 11 дүгээр зүйлийн 1, 2, 13 дугаар зүйлийн хоёрдахь заалтыг чанд сахиж, хил зөрчигч нь хил хамгаалагчдын эсрэг зэвсэг хэрэглэх буюу тэдний амь нас, аюулгүй байдалд заналхийлэхээс бусад тохиолдолд хоёр Талын хил хамгаалагчид хил зөрчигчдийн эсрэг зэвсэг хэрэглэхгүй, хүнлэг бус хандахгүй, хилийн зөрчлийг дэвэргэхгүй байж, хил дээр болон хил давуулж буудахыг хориглоно.

Хилчид хил зөрчигчдийн эсрэг зайлшгүй зэвсэг хэрэглэхээс өөр аргагүй болбол зэвсэг хэрэглэхийн өмнө урьдчилан сануулах буюу анхааруулж буудна.

6 дугаар зүйл

Хил хамгаалалтын хамтын ажиллагааг бэхжүүлэхийн тулд хоёр Тал хилийн уулзалтын байруудын хооронд утсан холбоо тавьж болно.

Хилийн төлөөлөгчид хил дээр болсон асуудлын талаар бичгээр харилцана.

Харилцах журмыг хилийн төлөөлөгчид харилцан тохиролцоно.

7 дугаар зүйл

Хоёр Тал хил хамгаалах, хилийн дэглэмийг сахиулах талаар туршлага солилцох хэлбэрийг тухайн орон нутгийн хилийн төлөөлөгчид харилцан тохиролцоно.

8 дугаар зүйл

Хоёр улсын болон, цэргийн байгууллагын гол баярын өдрөөр Талуудын хилийн төлөөлөгчид харилцан бие биенээ урьж, баяр тэмдэглэх үйл ажиллагаанд оролцуулж, соёл урлаг, биеийн тамирын арга хэмжээг хамтран зохион байгуулж болно.

Хоёр Талын хилийн анги, салбаруудын хооронд урлаг соёл, биеийн тамирын арга хэмжээ зохион байгуулж, хил хамгаалах албаны зохион байгуулалт, хичээл сургалтын байдалтай танилцаж болно. Энэ үйл ажиллагааг хоёр Талын хилийн төлөөлөгчид харилцан тохиролцоно.

9 дүгээр зүйл

Хоёр Талын хил хамгаалах хамтын ажиллагаа нь аливаа гуравдагч орны эсрэг чиглэгдэхгүй.

10 дугаар зүйл

Хил хамгаалах хамтын ажиллагааны явцад гарсан асуудлыг Хоёр Тал тэгн эрхтэйгээр, найрсаг байдлаар хамтран шийдвэрлэнэ.

Хоёр Тал харилцан тохиролцсоны дагуу энэхүү хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт болон засвар оруулж болно.

11 дүгээр зүйл

Энэхүү хэлэлцээр нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн 5 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ. Уг хэлэлцээрийн хүчинтэй байх хугацаа дуусахаас 6 сарын өмнө аль нэг Тал нөгөө Талд түүнийг нуцлах тухай саналаа бичгээр мэдэгдээгүй бол энэхүү хэлэлцээр нь дараагийн 5 жил тутам хүчин төгөлдөр хэвээр байх болно.

Энэхүү хэлэлцээрт 1999 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр Бээжин хотноо гарын үсэг зурав. Хэлэлцээрийг Хятад, Монгол хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

БНХАУ-ЫН БАТЛАН
ХАМГААЛАХ ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ

陔福临

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН
ЦЭРГИЙГ УДИРДАХ ГАЗРЫН
ТӨЛӨӨЛЖ

